

ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ ХАНДАА ОВОГТОЙ
ПҮРЭВДОРЖИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхлэх, дуусан хугацаа	Биелэлти йн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах							
1.	1.1.1.Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах.	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	Монгол улсын хууль, УИХ-н тогтоол, Засгийн газрын тогтоол болон эдгээртэй уялдан гарсан журам, зөвлөмж, чиглэлийг байцаагч ажилтнуудад танилцуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан 1 дүрэм, 4 журам, 11 тогтоол, тушаал, шийдвэр, 12 заавар, зөвлөмж, 9 аргачлал, чиглэл, 17 тайлбар, судалгаа мэдээлэл ирүүлсэн бөгөөд тэдгээртэй танилцан үр дүнг тооцон ажиллаж байна.	2024.01.01 2024.12.31	100%
2.	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг	Эрсдэлийн үнэлгээний мэдээллийн сан, --Цахим	Хяналтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 76 ААН-ийг цахим	"Шилэн хяналтын цахим систем"-д 2024 оны эрсдэлийн үнэлгээг бүртгэж, эрсдэлийн	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх зориолгоор шинээр 200 аж ахуй нэгж байгууллагын судалгааг	2024.01.01 2024.12.31	100%

	дээшлүүлэх	системийн бүртгэл мэдээлэл, гүйцэтгэл, тайлан	бүртгэлд хамруулж эрсдлийн үнэлгээ хийсэн	ангилалд хамаарах объектын жагсаалтаар нэгдсэн цахим сан бүрдүүлсэн байна.	гаргаж 120 аж ахуй нэгжийн эрсдлийг үнэлж шилэн хяналтын "Эрсдэлийн үнэлгээний мэдээллийн сан, --Цахим системийн бүртгэл мэдээлэл"-л шивж оруулан судалгаандаа үндэслэн Салбарын 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамрагдах 17 аж ахуй нэгжийг сонгон жагсаалтыг батлуулахаар ГБХНХЯ-нд хүргүүлсэн.		
--	------------	---	--	---	---	--	--

Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

3.	3.2.3 Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан 2021-2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Шалгалт хийсэн объектын тоо, илэрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт	Суурь үзүүлэлт байхгүй	Төлөвлөгөөг хяналт шалгалтыг хийж дуусгах	Шалгалтыг Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө", Салбарын улсын Ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 13-07/08 дугаартай удирдамжид дурдсан асуудлын хүрээнд ХУД, СХД-ийн НДГ-ын YOMШӨС-ийн 2021-2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалттай холбогдох санхүүгийн баримт материал, YOMШӨС-аас тэтгэвэр авч байгаа иргэний мэдээллийг "Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан, "Тэтгэврийн программ", тэтгэврийн хувийн хэрэгтэй тулган, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн санхүүжилтээр урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал авч сургалт зохион байгуулсан 8-н аж ахуйн нэгж байгууллагыг шалгалтанд хамрууллаа. Хяналт шалгалтаар нийт 4 төрлийн зөрчил илэрлээ. 2021-2023 онд Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг	2024.02.15 2024.06.30	100%
----	--	---	------------------------	---	---	--------------------------	------

					холбогдох сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулахдаа Монгол Улсын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 (ил тод) байх; 4.1.7-дахь заалт (бодитой байх); 4.2.7. (аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх) ; Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно”, Зөрчлийн тухай хуулийн 10.17.6 “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан нь...”, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолын 4.1-дахь хэсэгт заасан “... энэ журмын 2.2 дахь хэсэгт зааснаас бусад өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна. 2023 оны 5 сарын 25 ны өдрийн Нийгмийн даатгалын Ерөнхий газрын дарга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн даргын нарын байгуулсан НД-62 тоот гэрээний хавсралтад дурьдсан “Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэн, малчид, жижиг дунд үйлдвэр, хоршоо, нөхөрлөлийн ажилтнуудад ХАБЭА-н чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах зардлын төсвийн хуваарийн дагуу Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд		
--	--	--	--	--	---	--	--

					зохион байгуулсан сургалтууд нь гэрээний хавсралтанд дурьдсан зорилтот бүлгийн иргэдэд зориулагдаагүй, хөтөлбөр тодорхой бус, гэрээний заалтын дагуу хийгдээгүй, сургалтанд зарцуулсан зардлын санхүүгийн анхан шатны баримт, материал байхгүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 2 дугаар бүлгийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан "Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно", Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолын 4.1-дахь хэсэгт заасан "... энэ журмын 2.2 дахь хэсэгт зааснаас бусад өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн байна. 2021-2023 онд Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэстэй харилцагч, шимтгэл төлөгч зарим ААНБ-гууд хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогод үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийг дутуу тооцож, төлөөгүй байгаа нь Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.3, 17 дугаар зүйлийн 17.1.1, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2, (2021-2023 онд үйлчилж байсан хүчин төгөлдөр хуулиар) Засгийн газрын 2017 оны 17 дугаар тогтоолын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна. Нэр бүхий тэтгэвэр авагчдын хувийн хэргийн бүрдлийн зарим баримт материал шаардлага хангахгүй, ажлаас чөлөөлөгдсөн тушаал байхгүй, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдийн гарын үсэг дутуу, архивын		
--	--	--	--	--	--	--	--

					тасгаас гаргасан цалингийн тодорхойлолт эх хувиараа байхгүй, хуулбарыг үндэслэсэн, нийгмийн даатгалын дэвтрийн баталгаажуу цалингаас тэтгэвэр тогтоосон нь Монгол Улсын Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.5, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 24 ны өдрийн А-31 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын холбогдох заалтыг тус тус зөрчсөн байна. Шалгалтаар нийт 18 заалт бүхий улсын байцаагчийн 4 акт /СХД-н НДГ-т 129951,8, ХУД-н НДГ-т 62546,08 төгрөг/, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 6 заалт бүхий улсын байцаагчийн 3 албан шаардлагыг ХУД, СХД-ийн НДГ, ХХҮХ-үүдэд өгч биелэлтийг 100% хангуулж ажилласан.		
4	3.2.4 Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 376 объектод төлөвлөгөөт шалгалт хийх	Хяналт шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо,	2023 онд 413 объектод хяналт шалгалт хийж, 1166 зөрчил илэрүүлж, 193 албан шаардлага гаргасан.	Шалгалтад хамрагдсан объектод хууль сахин мөрдөлтийн түвшинг +10%, Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлийн объектын түвшиг бууруулна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын хяналтын газрын дарга бөгөөд салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 07 өдрийн 13-07/10 тоот "Барилга угсралт болон барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн "Хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлах тухай" 420 дугаар тогтоолыг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилга угсралт болон барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа 15-н аж ахуйн	2024.01.01 2024.12.31	

		хувь			нэгж байгууллагуудад Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж холбогдох хяналтын хуудсаар эрсдлийн болон хууль сахин мөрдөлтийн түвшинг тогтоож, болзошгүй осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нартай хамтарч хяналт шалгалтыг 2024 оны 06 дугаар сарын 03-наас 2024 оны 10 дугаар сарын 01-ны дотор хийж гүйцэтгэсэн. Барилгын салбарын хяналт шалгалтад Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт барилга угсралт болон барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй дараах аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газраас төлөвлөсөн. Үүнд: 1. Эм Си Ти инженеринг ХХК /Өсөх дэнж хотхон / 2. Бармон ХХК / Шинэчлэл		
--	--	------	--	--	---	--	--

				хотхон / 3. Саран Инж ХХК /Барилга/ 4. Баярсонстракшн ХХК /Барилга / 5. АРБО ХХК /Барилга/ 6. ДБ интернэшнл ХХК /Барилга/ 7. Бостон интернэшнл ХХК /Барилга/ 8. Батлуу хийц ХХК /Барилга/ 9. Эко тулга ХХК /Барилга/ 10. Их Отгон ХХК /Барилга/ 11. Эс Ти Би Эс ХХК /Барилын материал үйлдвэрлэл/ 12. Теплохаус констракшн ХХК 13. Термосилит ХХК /Барилга угсралт/ 14. Адмант ХХК /Барилга угсралт/ 15. Асар өргөө ХХК /Барилга/ Барилгын салбарт хийсэн төлөвлөгөөт шалгалтанд 15 аж ахуйн нэгжээс 6 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүй зогссоныг албан тоотоор баталгаажуулан авч 9 аж ахуй нэгж байгууллагыг бүрэн хамруулж, 07.3.1 кодтой "Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас"-аар 9 аж ахуйн нэгж бага эрсдэлтэй шалгагдаж, Нийгмийн хамгааллын холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт 91.0 хувьтай байна.		
1 урлагын гудад эвлөгөөт галтыг	Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн	2023 онд Соёл, урлагын байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт хийгдээгүй	Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 420 дугаар тогтоолыг үндэслэн Соёлын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны салбарын хяналтын газрын улсын ерөнхий байцаагч нарын хамтарсан 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 05-00-001/04, 13-07/13 тоот Урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх тухай		

		зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь			удирдамжийн дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа соёл урлагын байгууллагуудад Соёлын тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг Соёлын яамны Салбарын хяналтын газрын улсын ахлах байцаагч Д.Отгонбаяр, Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч С.Бүрэнжаргал, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Ч.Сайнхүү, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Х.Пүрэвдорж миний бие хамтран 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ. 1. Дүрслэх урлагын музей (РД: 9081542) нь Хууль сахин мөрдөлт 98.1 хувь, эрсдэл үүсэх магадлал 1.9 хувь, эрсдлийн үнэлгээ / Бага / 2. Монголын үндэсний музей (РД: 9081569) нь Хууль сахин мөрдөлт 94.6 хувь, эрсдэл үүсэх магадлал 5.4 хувь, эрсдлийн үнэлгээ / Бага / 3. Байгалийн түүхийн музей (РД: 9081577) нь Хууль сахин мөрдөлт 97.6 хувь, эрсдэл		
--	--	--	--	--	--	--	--

					үүсэх магадлал 3.4 хувь, эрсдлийн үнэлгээ / Бага / Шалгалтаар нийгмийн хамгааллын чиглэлээр ажил мэргэжлийн ангиллыг Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолт заасны дагуу тайлагнаагүй, даатгуулагчийн ажилд орсон гарсан тушаалыг шимтгэлийн цахим системд оруулаагүй зэрэг зөрчлүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дах заалтын дагуу ахмадын сан байгуулаагүй Дүрслэх урлагын музей, Байгалийн түүхийн музейд улсын байцаагчийн 4 заалт бүхий 2 албан шаардлага, Монголын үндэсний музейд ажил мэргэжлийн ангилалыг тайлагнаагүй зөрчилд улсын байцаагчийн 2 заалт бүхий 1 албан шаардлага өгч ажилласан.		
5	Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх	Акт, Албан шаардлагын биелэлт (тоо, хувь) Зөрчил арилгалт (хувь)	2023 онд төлөвлөгөөт Шалгалтаар илэрсэн зөрчилд 946 заалт бүхий улсын байцаагчийн 193 албан шаардлага үйлдэж, 600 заалт биелэгдэж 63 хувьд хүрсэн. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 145 заалт бүхий	Албан шаардлагаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг дүгнэж, тайлагнах	- МУ-ын ЗГ-ын 2023.03.01-ний өдрийн "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай" 79 дүгээр тогтоол, НДЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан "Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх" удирдамжийн хүрээнд нийгмийн халамжийн сан болон нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон давхардуулан авч буй эсэхэд хяналт шалгалт хийгж тэжээгчээ алдсаны тэтгэвэр болон өндөр насны тэтгэврийг давхардуулан олгосон нэр бүхий 1 иргэний давхардсан хугацааны 4684,0 мянган төгрөгийн актыг 100% барагдуулсан байна. - "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо" ГҮТББ-ын 74,700,0 мян. төгрөгийн тусгай хэрэгсэлийг олгоогүй	2024.06.01 2024.12.31	100%

			улсын байцаагчийн 58 албан шаардлагыг хүргүүлсэн ба 76 заалт 52 хувьтай байна. Мөн 1757 иргэнтэй холбоотой 1,145.7 сая төгрөгийг Санд нөхөн төвлөрүүлэх, 166 иргэнтэй холбоотой 27.2 сая төгрөгийг иргэн даатгуулагчид олгуулах нөхөн төлбөрийн нийт 211 заалт бүхий 83 акт тогтоож, нөхөн төлбөрийн биелэлт 15 хувьтай байна.	зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн. - Протез ортепед тусгай хэрэгсэл, амралт сувилал бусад үйл ажиллагаа эрхэлдэг 14 аж ахуй нэгжид 28,550,0 мян. төгрөгийн актаас 26,740,0 мян. төгрөгийг барагдуулсан /93,7%/. -СХД-н ХХҮХ- 35,373,8 мян. төгрөгийн актаас 29,781,8 мян.төгрөг /84,2%/ ЧД-н ХХҮХ-8,117,6 мян.төгрөгийн актаас 5,337,6 мян.төгрөг /65,8%/, БГД-н ХХҮХ-10,780,8 мян. төгрөгийн актаас 4,340,8 мян.төгрөг /40,3%/ БХД-н ХХҮХ- 2,067,1 мян.төг актаас 1,962,1 мян. төгрөг /94 7%/, БНД-н ХХҮХ-4,040,5 мян. төгрөгийн актаас 3,206,5 мян. төгрөгийг актыг барагдуулсан байна. -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2023.08.24-ны өдрийн 07/22 тоот удирдамжийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтийн гүйцэтгэлийн хяналт шалгалтаар СХД-н ХХҮХ-т 39,885,0 мян.төгрөгийн акт-аас 37,985,0 мян. төгрөг /95,2%/ барагдуулсан. ЧД-н ХХҮХ-ийн 47,545,0 мян.төгрөгийн актаас 32,300,0 мян.төгрөг /68%/ барагдуулалттай байна. Нийт 204,266,3 мян. төгрөгийн акт үйлдсэнээс 151.429.9 мян.төгрөг /74,1%/-ийн актыг барагдуулан ажилласан.		
--	--	--	--	---	--	--

Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.

Төрийнзахиргааныудирдлагынманлайллыгхангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрхзүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээгхөгжүүлэхзамаарбайгууллагынтогтвортойхөгжлийгхангах

6	Цаг үеийн шаардлага болон шуурхай хурал, удирдлагаас өгсөн үүрэг	Шуурхай хурал тухай бүр оролцож өгсөн үүрэг даалгарыг	Чиг үүргийн дагуу удирдах дээд шатны байгууллага, удирдах ажилтнаас өгсөн үүрэг	МУ-ын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих услах үйл	2024.01.01 2024.12.31	100%
---	--	---	---	--	--------------------------	------

	даалгавар хэрэгжилтийг хангаж ажиллана.	тухаа бүр биелүүлнэ.		даалгврыг цаг тухай бүр биелүүлж ажиллана.	ажиллагаанд оролцсон -Европын Холбооны санхүүжилттэй "МУ-д ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслийн хүрээнд ХНХСалбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхижуулах 16 цагийн сургалтанд 11 сарын 25,26-нд хамрагдсан.		
7	Удирдах байгууллага, албан тушаалтанаас гаргасан шийдвэрийн хүрээнд хяналт шалгалт гүйцэтгэх	Шалгалт хийсэн объектын тоо, Илрүүлсэн зөрчил, арилгуулалтын тоо, хувиар	Суурь үзүүлэлт байхгүй	Иргэн, Аж ахуйн нэгж байгууллагад учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03 дугаартай Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлт, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг шалгах ажлын удирдамж, шалгах хуваарийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон ноогдуулалт, мэдээлэлийн сангийн бүрдүүлэлт, даатгуулагчийн төрөл, тайлан авалтын хугацаа, нөхөн тайлангийн үндэслэл болон залруулгын тайлан зэргийг мэдээлэлийн сантай тулган шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр бүрэн засуулж арилгуулан ажиллав. Орлого, шимтгэлийн байцаагчийн хүлээн авсан ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл төлөлтийн тайлангын үндэслэлийг НДЕГ-н даргын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/186 тоот тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтын нэгдсэн заавар"-ыг баримтлан ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон шимтгэлийн тооцооны программын үлдэгдлүүдийг тулган, шимтгэлийн өр авалгатай ААНБ-тай хийсэн тооцоо нийлсэн актын баталгаажуулалт мөн тоон гарын үсгээр баталгаажуулсан нийт 706 тайланг	2024.01.01 2024.12.31	100%

					шалгасан. Цахим хяналтын системд тулгуурлан дотоодын хяналт шалгалтын мэдээллийг тогтмол хийж байна. НДЕГ-н даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024.10.03-ны өдрийн "Аж ахуйн нэгж байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж"-н хүрээнд Монгол улсын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Олон улсын байгууллага, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, салбар, төлөөлөгчийн болон төлөөний газарт Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд 3, Газрын даргын 2024.10.14-ны өдрийн "Аж ахуйн нэгж байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах удирдамж"-ийн хүрээнд нийгмийн даатгалын байгууллагад 10 саяас төгрөгийн шимтгэлийн өглөгтэй 29-н аж ахуйн нэгж байгууллага,		
8	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт (тоо, хувь) Зөрчил арилгалт (хувь)		Иргэн, Аж ахуйн нэгж байгууллага, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	2024 оны жилийн эцсийн байдлаар ажил олгогчийн ирүүлсэн хүсэлтийн дагуу цалингийн мэдээлэл устгасан, өөрчилсөн, код буруу шивэгдсэн, нөхөн тайлан өгсөн, улсын байцаагчийн актаар тайлан шивсэн, нийт давхардсан тоогоор 35 ажил олгогчийн 49 даатгуулагчийн баримтыг үндэслэн цахим хяналтыг мэдээлэлийн сантай тулган нотлох баримтыг хавсарган залруулан ажиллаж байна. Дүүргийн иргэдийн төлөөлөгчдын хурлын ажлын алба бусад холбогдох төрийн байгууллагуудтай хамтран 7 шашны байгууллагад хяналт шалгалтыг хийсэн.	2024.01.01 2024.12.31	100%

9	Арга хэмжээ 4.1.10. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх	Хуулийн хэрэгжилт хангах	ХАСХОМ-ын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь үнэн зөв гаргаж ЭБАТ-аар баталгаажуулсан	ХАСХОМ-ын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь үнэн зөв гаргаж ЭБАТ-аар баталгаажина.	Авилгатай тэмцэх үндэсний хөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд нь 2 удаа гаргаж баталгаажуулан ажиллалаа	2024.01.01 2024.02.15	100%
10	4.1.11 Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын дагуу хөтлөн явуулан холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	ERP цахим системийн ашиглалтыг сайжруулах, зөрчлийг бууруулна.	ERP цахим системийн ашиглалтыг сайжруулах, зөрчлийг бууруулна	ERP цахим системийг бүрэн ашиглана.	ERP цахим системийг ашиглан EDOC-н бүртгэл, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын дагуу хөтлөн 31 байгууллагын хүсэлтийг явцын тэмдэглэл хөтлөн шийдвэрлэсэн.	2024.01.01 2024.12.31	100%
11	4.1.12 Төрийн албан хаагчийн хувийн хэргийг зохих журмын дагуу хөтлөх, баяжилтыг тухай бүр шинэчлэх	Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмыг хэрэгжилтийг хангах	Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу хувийн хэргийн баяжилт хийсэн.	Төрийн албан хаагчийн анкетыг шинэчилж, хувийн хэргийн баяжилтыг тухай бүр хийсэн байна.	Төрийн албан хаагчийн анкетыг шинэчилж, ННДГазар татан буугдсантай холбоотой тушаал шийдвэр, ХАСХОМ, хувийн хэргийн баяжилтыг дахин хийсэн.	2024.01.01 2024.05.31	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхлэх, дуусан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7
1		Мэдлэг ур чадвар, хууль эрх зүйн	Мэдлэг ур чадвар, хууль эрх зүйн	Салбарын сургалтанд	-Зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай	2024.01.01 2024.12.31	100%

	НДЕГ, ТАЗ, -өөс зохион байгуулсан салбарын сургалтанд хамрагдана.	мэдлэг дээшилнэ.	мэдлэг дээшилнэ.	хамрагдана.	хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн талаарх сургалтад хамрагдсан. -Европын Холбооны санхүүжилттэй "МУ-д ТХЗ-той уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслийн хүрээнд ХНХСалбарын хяналтын улсын байцаагчдыг чадавхижуулах 16 цагийн сургалтанд 11 сарын 25,26-нд хамрагдсан		
2	Монгол бичгийн сургалтанд хамрагдана	Мэдлэг, чадвар дээшилнэ	Бие даан анхан шатны сургалтанд цахимаар суралцсан	дунд шатны сургалтанд хамрагдана.	Монгол бичгийн дунд шатны сургалтанд цахимаар суралцсан.	2024.01.01 2024.12.31	100%

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН БИЧСЭН:
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:
ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Х.Пүрэвлорж

Х.ПҮРЭВЛОРЖ

2024.

Т.ГЭРЭЛТУНГАЛАГ

2024.....